



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 28 өдөр

Дугаар 1/202

Хархорин сум

Г Эзэмшил газрын хэлбэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4 дэх хэсэг, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 8.1.6 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Од 9-17 тоотод байрлалтай 1200м² газрыг Содномын Нямсүрэн худалда нийтийн үйлчилгээний зориулалтаар эзэмшиж байгаа тус газрыг тухайн зориулалтаар хэмжээ байршил өөрчлөхгүйгээр хэлбэрийг нь өөрчлөн эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмигч “С.Нямсүрэн”-д газар эзэмших эрхийн эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (А.Норпил), (Ч.Баттулга) нарт даалгасугай.

3. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, газрыг зориулалтын дагуу эзэмших, газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн барагдуулж байх, Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг (С.Нямсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын газар эзэмшүүлэх тухай 2013 оны А/236 дугаар захирамжийн С.Нямсүрэнтэй холбогдох хэсэг, 000439971 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА Г.ОДГЭРЭЛ



101190483